

Моннисийн тэтгэлэг

Тавигдах шаардлага:

- Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулийн бакалаврын зэргийн өдрийн ангийн оюутан,
- Сургуулийн үнэлгээний системээс хамаарч сурлагын голч дүн,
- 4,0 сургуулийн оюутнууд 3,5 дээш байх,
- 100%-ийн үнэлгээтэй сургуулийнх 90%-с дээш байх,
- Оюутны эрдэм шинжилгээний ажилд тодорхой амжилттай оролцож байсан,
- Англи хэлийг дундаас дээш түвшинд эзэмшсэн байх,
- Нийгэм олон нийтийн ажил, урлаг спортын тэмцээн, олимпиад бусад арга хэмжээнүүдэд амжилттай оролцож байсан.

Бүрдүүлэх материал:

- Анкет (Ниссан төвийн байр, вэб хуудаснаас авах)
- Суралцагчийн өргөдөл
- Сургуулийн албан ёсны тодорхойлолт эсвэл сургуулийн томилолт
- Баталгаажуулсан дүнгийн жагсаалт, голч дүнгийн хамт эсвэл ЕБС-ийн аттестат
- Өөрийгөө сайн мэдэх 2 багшийн тодорхойлолт, багшаар битүүмжлүүлсэн байх, холбогдох дугаарын хамтаар
- Эрдэм шинжилгээний бүтээл, илтгэлийн жагсаалт эсвэл спорт, урлагаар амжилт гаргаж байсныг гэрчлэх материалуудын хуулбар
- “Миний ирээдүйн зорилт” сэдвээр 250 үгтэй эссэ бичих

Дэлгэрэнгүйг www.monnis.com хаягаас үзээрэй. Миний хувьд тус тэтгэлэгт материалаа өгсөн хэдий ч тэнцээгүй. Шалтгааныг асуухад бидний зорилтот мэргэжлээр суралцаж буй оюутан биш байсан болов уу гэж хүний нөөцийн ажилтан нь хэлсэн. Тиймээс Нийгмийн шинжлэх ухаанаар суралцаж буй оюутны хувьд боломж бага гэж ойлгосон. Гэхдээ материалаа өгөөд үзэх л хэрэгтэй.

Энэ мэт дотооддоо суралцаж буй оюутнуудад хэрэгтэй маш олон тэтгэлэгүүд байдаг. Энэхүү нийтлэлдээ би зөвхөн өөрөө авч байсан болон материалаа өгч оролцож байсан тэтгэлгүүдээ багтаасан болно. Чамд амжилт хүсье!

Жич: Чи ч бас дотоодын, эдгээрээс гадна ямар нэг тэтгэлгийг авч байсан эсвэл авахаар оролдож байсан бол оюутан бүсгүйчүүдэд өөрийнхөө туршлагаас хуваалцаж яагаад болохгүй гэж?